



*МОНГОЛЫН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН
ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГА*

**ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГЫН
ХЭРЭГЖИЛТИЙГ ОРОН НУТАГТ ХАНГАХ ҮҮРЭГ БҮХИЙ
ДЭД ЗӨВЛӨЛИЙН ГАРЫН АВЛАГА**

*АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ДЭД ЗӨВЛӨЛИЙН ДАРГА, ГИШҮҮД,
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА НАРТ ЗОРИУЛАВ*

2014 оны 4 дүгээр сар

Монголын ОУИТБС-ын ажлын алба бэлтгэв. Холбоо барих хаяг:
Зохицуулагч Ш.Цолмон: 99196972, eti.secretariat.mn@gmail.com
Харилцааны мэргэжилтэн Б.Дэлгэрмаа: 88007870, eti.communication@gmail.com
Санхүүгийн мэргэжилтэн А.Отгонтунгалаг: 99045960, eti.finance@gmail.com
Мэдээлэл, технологийн зөвлөх Г.Ганбат, 88076673, gganbat@gmail.com
Улаанбаатар хот, СБД-14200, А.Амарын гудамж, Туушин Тауэр, 314 тоот
У: 70110525, Ф: 70110155, www.eitimongolia.mn , facebook: EITI Mongolia

Товъёог

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга гэж юу вэ?	3
Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга юу хийдэг вэ?	3
Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын засаглал?.....	4
ОУИТБС-ын хүрээнд баримтлах үндсэн баримт бичиг юу вэ?.....	4
Монгол Улс ОУИТБС-д хэзээ нэгдэн орсон бэ?.....	4
Монгол Улсын ОУИТБС-ын бүтэц, зохион байгуулалт?	5
Монгол Улсад ОУИТБС-ын тайланг хэн гаргах вэ? ямар эрх зүйн баримт бичигт үндэслэн гаргадаг вэ?	5
ОУИТБС-ын тайлангийн маягыг хэн баталдаг вэ? хаанаас авах вэ?	6
ОУИТБС-ын тайлан гаргах журам	6
Монгол Улсын ОУИТБС-ын тайлан гаргалтын байдал.....	7
ОУИТБС-ын эрхэм зорилго	8
ОУИТБС-ын үр дүнгийн хэлхээ	8
ОУИТБС-ын дэд зөвлөлийн чиг үүрэг.....	8
Дэд зөвлөлийн үйл ажиллагааг хэрхэн үр дүнтэй зохион байгуулж, төлөвлөх вэ?	11
Үр дүнд чиглэсэн оновчтой зорилго, зорилт гэж ямар байх вэ?	12
ОУИТБС-ын тайлангаар ил тод мэдээлэгддэг татвар, төлбөрүүд.....	13
Хандив, дэмжлэг тайлагнахад анхаарах асуудлууд.....	17
Мөнгөн болон мөнгөн бус хандив, дэмжлэгтэй холбоотой асуудлууд?.....	18
Жил бүрийн аудитын нэгтгэлээр тулгардаг асуудлууд, анхаарах зүйлс:	20

ХАВСРАЛТУУД

1. Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 1-р тогтоол
2. Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 222-р тогтоол
3. Монгол Улсад ОУИТБС-ыг хэрэгжүүлэх бүтэц, бүрэлдэхүүн
4. Монгол Улсын Ашигт малтмалын тухай, Цөмийн энергийн тухай хуулиас
5. Сангийн сайд, Үндэсний статистикийн хорооны даргын 2013 оны 1 сарын 3-ны 1/31/1 тоот хамтарсан тушаал
6. ОУИТБС-ыг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны (2010-2014 он) стратеги
7. Монгол Улсад ОУИТБС-ыг хэрэгжүүлэх 2014 оны төлөвлөгөө
8. ОУИТБС-ын дэд зөвлөлийн үлгэрчилсэн дүрэм
9. Дэд зөвлөл байгуулагдсан аймгууд, бүтэц, бүрэлдэхүүн
10. 2013 онд орон нутагт зохион байгуулсан бүсийн чуулга, уулзалтуудын тайлан
11. ОУИТБС-ын мэдээллийн самбарын загвар, стандарт
12. ОУИТБС-ын олон улсын шинэ стандарт




Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг орон нутагт хэрэгжүүлэх үүрэг бүхий дэд зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга нарт зориулсан гарын авлага

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга гэж юу вэ?

Эрдэсийн баялгаас (ашигт малтмал, газрын тос, байгалийн хий) олж буй орлогыг олон нийтэд ил тод болгосноор түүнийг нийтийн сайн сайхны төлөө зөв захиран зарцуулахад нь оролцогч талуудын хариуцлагыг өндөржүүлэх, сайн засаглалыг бэхжүүлэхэд чиглэсэн төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн тэгш оролцоо бүхий дэлхий нийтийн түншлэл юм.

Одоогоор байгалийн баялаг ихтэй дэлхийн 44 орон ОУИТБС-ыг хэрэгжүүлэхээр нэгдэн орж, тэдгээрийн 26 улс нь ОУИТБС-ын шаардлагыг хангаад байна. Дэлгэрэнгүйг www.eiti.org - оос




Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга юу хийдэг вэ?



байгууллага тулган баталгаажуулалт хийж, түүнийг олон нийтэд ил тод болгоно.

Нэг талаас олборлох үйлдвэрлэл эрхлэгч компаниуд төлснөө тайлагнана, нөгөө талаас Засгийн газар тэдгээр компаниудаас хүлээн авсан орлогоо тайлагнана. Хоёр талаас ирүүлсэн тайланг олон улсын хөндлөнгийн аудитын аудитаар баталгаажсан нэгдсэн тайлан гаргаж,



Энэхүү үйл явцыг төр, компани, иргэний нийгмийн тэгш оролцоо бүхий олон талт оролцогчдын бүлэг удирдан явуулж, хянан зохицуулна.

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын засаглал?

Олон улсын бага хурал: 2 жил тутам ОУИТБС-ыг хэрэгжүүлэгч улс орнууд чуулж, асуудлуудыг нээлттэй хэлэлцэж, шийдвэр гаргана.

Олон улсын удирдах хороо: Хэрэгжүүлэгч улс орнуудын төр засгийн төлөөлөл, үндэстэн дамнасан олборлох үйлдвэрлэлийн томоохон корпорациуд, иргэний нийгмийн олон улсын сүлжээ нийгэмлэгүүдээс бүрдэх ба гишүүд нь 2 жилээр сонгогдоно. ОУУХ-ноос ОУИТБС-д баримтлах үндсэн зарчим, хэрэгжүүлэгч орнуудын мөрдөх дүрэм, стандарт зэрэг суурь баримт бичгүүдийг боловсруулж, батална. Түүнчлэн ОУИТБС-д нэгдэн орох, шаардлагыг хангасан хэрэгжүүлэгч орноор хүлээн зөвшөөрөх зэрэг гишүүнчлэлтэй холбоотой шийдвэрүүдийг гаргана.

Баталгаажуулалтын хороо: Олон улсын удирдах хорооноос гаргасан баримт бичигт тулгуурлан ОУИТБС-д нэгдэн орсон улс орнуудад стандартын дагуу хэрэгжүүлж буй эсэх дээр хөндлөнгийн үнэлгээ хийж, тухайн оронд чанарын хяналт тавина.

Олон улсын нарийн бичгийн дарга нарын газар: ОУИТБС-ын хэрэгжилтийг хариуцах ба бүх шаардлагатай зохицуулалтуудыг хариуцна, гишүүн улс орнуудыг заавар, арга зүйгээр хангана.

ОУИТБС-ыг хэрэгжүүлэгч орнуудын олон талт оролцогчдын бүлэг: Хэрэгжүүлэгч улс орнууд ОУИТБС-ыг хэрэгжүүлэх, удирдан чиглүүлэх үүрэг бүхий төр, компани, иргэний нийгмээс бүрдсэн олон талт оролцогчдын бүлгийг байгуулна.

ОУИТБС-ын хүрээнд баримтлах үндсэн баримт бичиг юу вэ?

ОУИТБС-ын хүрээнд баримтлах 12 зарчим, 2013 оны 5 дугаар сард шинэчлэн баталсан ОУИТБС-ын стандартыг бүх хэрэгжүүлэгч улс орнууд дагаж мөрдөх үүрэгтэй. ОУИТБС-ын шинэ стандартаар ганцхан төлбөр, орлогыг ил тод болгоод зогсохгүй, тусгай зөвшөөрөл, гэрээ, бенефициар өмчлөг, үйлдвэрлэл, борлуулалт, төрийн өмчит компаниуд зэрэг өргөн хүрээнд ил тод байдлыг хангах шаардлагатай болсон. Дэлгэрэнгүйг www.eitimongolia.mn –ээс

ОУИТБС-ын шинэ стандарт болон баримтлах 12 зарчмыг хавсралт 1-ээс үзнэ үү.

Монгол Улс ОУИТБС-д хэзээ нэгдэн орсон бэ?

2006 оны 1 дүгээр сард Монгол Улсын Засгийн газар 1 тоот тогтоол гаргаж, Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэхээ олон нийтэд зарласан юм.

<http://www.eitimongolia.mn/page/230.shtml?sel=499>

Монгол Улсын ОУИТБС-ын бүтэц, зохион байгуулалт?

ОУИТБС-ын Үндэсний зөвлөл – Удирдах дээд байгууллага

- Дарга: Монгол Улсын Ерөнхий сайд
- Орлогч дарга: Уул уурхайн сайд
- Гишүүд: УИХ, Засгийн газраас 10, компаниас 10, иргэний нийгмээс 10 (Орон нутгийг Төв аймаг төлөөлж байна.)
- Нарийн бичгийн дарга: Ерөнхий сайдын ахлах зөвлөх
- Хуралдаан: Жилд 1-оос доошгүй удаа
- Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор байгуулагддаг, ажиллах дотоод журамтай

ОУИТБС-ын Ажлын хэсэг – Зохицуулалтын үндсэн байгууллага

- Ахлагч: Ерөнхий сайдын ахлах зөвлөх
- Гишүүд: Засгийн газраас 11, компаниас 11, иргэний нийгмээс 11 (Орон нутгийг Сэлэнгэ аймаг төлөөлж байна.)
- Нарийн бичгийн дарга: АА-ны зохицуулагч
- Хуралдаан: Улиралд 1-ээс доошгүй удаа
- Төрийн төлөөллийг Монгол Улсын Ерөнхий сайдын захирамжаар, компаниудын төлөөллийг Монголын Үндэсний уул уурхайн ассоциацийн ерөнхийлөгчийн тушаалаар, иргэний нийгмийн төлөөллийг Төлсөн авснаа нийтэл эвслийн зохицуулагч, Монголын байгаль орчны иргэний зөвлөлийн даргын тушаалаар тус тус томилж, чөлөөлдөг. Ажиллах дотоод журамтай

ОУИТБС-ын Ажлын алба – Өдөр тутмын үйл ажиллагаа

- 4 орон тооны ажилтантай. Ажлын албаны дотоод дүрэмтэй

Орон нутгийн дэд зөвлөл - Орон нутагт хэрэгжүүлэх үүрэгтэй

- Аймаг, нийслэлийн дэд зөвлөл нь Засгийн газрын 2012 оны 222-р тогтоолд үндэслэн аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдана.
- Сумдын салбар зөвлөл нь Засгийн газрын 2012 оны 222-р тогтоол, аймгийн Засаг даргын захирамжид үндэслэн байгуулагдана.
- Орон нутгийн засаг, захиргаа, компани, иргэдийн төлөөллөөс бүрдэнэ.
- Дэд зөвлөлийн дарга нь Засаг даргын орлогч байна. Нарийн бичгийн дарга нь уул уурхайн асуудал эрхэлсэн газар, хэлтсийн дарга эсхүл мэргэжилтэн байна.
- Монголын ОУИТБС-ын Үндэсний зөвлөлөөс баталсан дэд зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн дүрмийг үйл ажиллагаандаа ашиглаж болно.

Монголын ОУИТБС-ын Үндэсний зөвлөл, ажлын хэсгийн бүтэц, бүрэлдэхүүний дэлгэрэнгүйг хавсралтаас үзнэ үү.

Монгол Улсад ОУИТБС-ын тайланг хэн гаргах вэ? ямар эрх зүйн баримт бичигт үндэслэн гаргадаг вэ?

Газрын тос, ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмалын компаниуд Ашигт малтмалын тухай хуулийн 48.10 дугаар заалт, Цөмийн энергийн тухай хуулийн 26.6.4 заалтууд, Монгол Улсын Засгийн газрын 1-р тогтоол, Үндэсний статистикийн хорооны дарга, Сангийн сайдын 2013 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн 1/31/1 тоот хамтарсан тушаалын дагуу ОУИТБС-ын тайланг 1,2,3 дугаар маягтаар жил бүр гаргаж, олон нийтэд мэдээлэх үүрэгтэй.

Төр, засгийн байгууллагууд Монгол Улсын Засгийн газрын 2006 оны 1-р тогтоол, 2012 оны 222 дугаар дугаар тогтоол, Үндэсний статистикийн хорооны дарга, Сангийн сайдын 2013 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн 1/31/1 тоот хамтарсан тушаалын дагуу ОУИТБС-ын тайланг 4, 5, 6 дугаар маягтаар жил бүр гаргаж, олон нийтэд мэдээлэх үүрэгтэй.

ОУИТБС-ын тайлангийн маягтыг хэн баталдаг вэ? хаанаас авах вэ?

Монгол Улс ОУИТБС-ын 7 маягттай. Маягтуудыг ОУИТБС-ын Ажлын хэсэг, Үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн батлаад, улмаар Сангийн сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан тушаалаар баталдаг. Хамгийн сүүлд 2013 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр 4 дэх удаагаа шинэчлэн баталсан болно.

1 дүгээр маягтыг ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй компаниуд, 2 дугаар маягтыг хайгуулын тусгай зөвшөөрөлтэй компаниуд, 3 дугаар маягтыг газрын тосны компаниуд бөглөдөг.


4 дүгээр маягтыг орон нутгийн засаг захиргаа, 5 дугаар маягтыг яам, агентлагууд бөглөж ТЕГ-т хүргүүлж, 6 дугаар маягтыг Сангийн яам баталгаажуулж, Засгийн газрын тайланг гаргадаг.

7 дугаар маягтыг Ашигт малтмалын газар гаргаж, тухайн жилд үйлдвэрлэсэн, борлуулсан бүтээгдэхүүний тайланг гаргадаг.




Тайлангийн маягт, нөхөн зааврыг <http://www.eitimongolia.mn/home.shtml> болон АМГ-ын www.mram.gov.mn цахим хуудаснаас татан авж болно.

ОУИТБС-ын тайлан гаргах журам

Санхүүгийн жилийн эхэнд АМГ-аас урд оны 1 сарын 1-нээс 12 сарын 31-ны хооронд хүчин төгөлдөр тусгай зөвшөөрөл эзэмшиж буй байгууллагуудын жагсаалтыг гаргана. Уг жагсаалтаар тухайн онд хэдэн компани ОУИТБС-ын тайлан гаргах үүрэгтэйг тодорхойлно. Энэхүү жагсаалтыг ТЕГ-т хүргүүлснээр ТЕГ Засгийн газрын тайланд хамрагдах компаниудын нэрс тодорхой болно. Төр, засгийн байгууллагууд тайлан гаргахдаа өөрийн орлогын дансны мэдээлэл, бүртгэлийн сангаас мэдээг түүж гаргах учиртай. Зарим тохиолдолд орон нутгийн татварын хэлтсүүд компаниар 4-р маягтыг бөглүүлэх, бэлэнчлэх тохиолдол гардаг. ОУИТБС-ын тайлангийн зорилго нь нэг талаас өгснөө, нөгөө талаас хүлээн авснаа тусдаа тайлагнаж, түүнийг хөндлөнгийн аудитор тулган баталгаажуулах, зөрүүтэй тохиолдолд юунаас болсныг тодорхойлж, ил тодоор үнэн зөв гаргахад оршдог. Дараах графикаас дэлгэрэнгүй харна уу.



2006 оноос хойш Монгол Улсын ОУИТБС-ын тайлан гаргалтын байдал




	2006	2007	2008	2009	2010	2011	2012
Улсын төсвийн урсгал орлого	1,354,098	1,855,936	2,151,049	1,972,619	2,670,243	4,018,298	4,840,792
Нэгтгэлийн тайлангаар нотлогдсон дүн	492,287	745,000	686,053	737,524	1,275,694	2,150,808	1,594,115
Улсын төсвийн урсгал орлогын дүнд эзлэх хувь	36%	40%	32%	37%	48%	54%	33%
Нэгтгэлийн тайланд хамрагдсан компани	25	38	46	101	150	200	200

Дэлгэрэнгүйг www.eitimongolia.mn-ээс

ОУИТБС-ын эрхэм зорилго

Эрдсийн баялгаас (ашигт малтмал, газрын тос, байгалийн хий) олж буй орлогыг олон нийтэд ил тод болгосноор түүнийг нийтийн сайн сайхны төлөө зөв захиран зарцуулахад нь оролцогч талуудын хариуцлагыг өндөржүүлэх, сайн засаглалыг бэхжүүлэхэд нөлөөлөх чухал хүчин зүйл болох

ОУИТБС-ын үр дүнгийн хэлхээ



ОУИТБС-ын дэд зөвлөлийн чиг үүрэг

Монгол Улсын Засгийн газрын 222-р тогтоолд зааснаар Аймаг, нийслэлийн Засаг дарга нар Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын хэрэгжилтийг орон нутагт хангах зорилгоор ОУИТБС-ын дэд зөвлөл байгуулж, ажиллуулах үүрэг хүлээсэн.

Тус тогтоолоор дараах 5 төрлийн чиг, үүргийг бүх шатны Засаг дарга нарт өгсөн байдаг. Үүнд:

1. Ашигт малтмал, газрын тосны компаниуд, тэдгээрийн туслан гүйцэтгэгчээс орон нутгийн төсөвт хүлээн авсан татвар, төлбөр, хандив, дэмжлэгийн орлогын мэдээг жил бүр гаргаж, нийтэд мэдээлэх, 4 дүгээр сарын 15-ны дотор ТЕГ-т хүргүүлэх

2. Ашигт малтмал, газрын тосны компаниуд, тэдгээрийн туслан гүйцэтгэгчээс орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр, хандив, дэмжлэгийн талаар иргэдэд нээлттэй мэдээлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий ОУИТБС-ын дэд зөвлөлийг төр, компани, иргэний нийгэм гэсэн гурван талын тэгш оролцоо, бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, үйл ажиллагаанд нь хяналт тавих
3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, тэдгээрт оруулсан өөрчлөлт, байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд төвлөрүүлсэн байдал, түүний зарцуулалт, буцаан төлөлтийн мэдээг аж ахуйн нэгж бүрээр гаргаж, дэд зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх, нийтэд ил тод мэдээлэх
4. Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар заалтын хэрэгжилтийг нийтэд мэдээлэх
5. Нутаг дэвсгэрт нь уул уурхайн үйлдвэрлэл явагдаж байгаа суманд ОУИТБС-ын дэд зөвлөлийг байгуулж, ажиллуулах зохион байгуулалтын арга хэмжээ авах

ОУИТБС-ын ажлын хэсэг, ажлын алба дэд зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, тогтмолжуулах зорилгоор анхлан 2013 оны 7 дугаар сарын 4-ны өдөр уул уурхай бүхий 13 аймгийн Засаг даргын орлогч нар, уул уурхайн асуудал эрхэлсэн газар, хэлтсийн дарга, мэргэжилтнүүд, орон нутгийн иргэний нийгмийн байгууллагуудыг оролцуулсан “ОУИТБС-ын дэд зөвлөл ба иргэний нийгмийн оролцоо” сэдэвт сургалт, хэлэлцүүлгийг Улаанбаатар хотноо зохион байгуулж, ОУИТБС-ын тухай нэгдсэн ойлголт өгч, дэд зөвлөлийн ажиллах журмын төслийг боловсруулж, танилцуулан санал авч, улмаар дэд зөвлөлийг хэрхэн үр дүнтэй ажиллуулах чиглэлээр бүлгийн хэлэлцүүлэг хийсэн.

Түүнчлэн уг журмын төслийг илүү боловсронгуй болгох, ОУИТБС-ын хэрэгжилтийг орон нутагт хангах зорилгоор 2013 онд нийт 20 аймгийг хамарсан 4 бүсийн чуулга уулзалтуудыг Ховд, Хэнтий, Дархан-Уул аймаг, Улаанбаатар хотноо тус тус зохион байгуулж, төр, компани, иргэний нийгэм, нутгийн иргэдийн төлөөлөл бүхий нийт 600 гаруй оролцогч нарт мэдээлэл хийж, дэд зөвлөлийг үр дүнтэй ажиллуулах сэдвээр олон талын оролцоотой хэлэлцүүлэг хийж, санал солилцсон болно.

Улмаар дээрх бүсийн чуулга уулзалтуудаас гарсан санал, санаачилгыг ОУИТБС-ын дэд зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн дүрэмт тусган, эцэслэж ОУИТБС-ын Ажлын хэсгийн 2013 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаар, Монгол Улсын Ерөнхий сайдын тэргүүлсэн ОУИТБС-ын Үндэсний зөвлөлийн 2013 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанд танилцуулж, батлуулсан болно.

Дэд зөвлөл нь дээрх үлгэрчилсэн дүрэм болон ОУИТБС-ын олон улсын шинэ стандарт, зарчим, Монгол Улсын ОУИТБС-ын дунд хугацааны стратеги, жил бүрийн ажлын төлөвлөгөө зэрэг олон улсын түвшинд болон үндэсний түвшинд баталсан эрх зүйн баримт, бичгүүдийг ОУИТБС-ын хэрэгжилтийг өөрийн нутаг оронд хангахдаа баримтлах, мөрдлөг болгох, гол чиглэл болгох нь зүйтэй.

Дэд зөвлөлийн үйл ажиллагааны төрөл

Дэд зөвлөлийн үйл ажиллагаа нь дараах 3 төрөл, бүлэгт хуваагдаж байна. Үүнд:

1. Судалгаа, мэдээ, тайлан гаргах
2. Тайлан мэдээг иргэдэд нээлттэй, ил тод мэдээлэх, олон талын оролцоотой хэлэлцүүлэг өрнүүлэх

3. Хамтын ажиллагаа, түншлэх хөгжүүлэх, оролцогч талуудын чадавхи бэхжүүлэх

Судалгаа, мэдээ, тайлан гаргах ажлын хүрээнд:

1. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн мэдээ гаргах
2. Бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын мэдээ гаргах
3. Орон нутгийн төсөвт хүлээн авсан татвар, төлбөр, хандив, дэмжлэгийн мэдээ гаргах, түүнийг 4 сарын 15-ны дотор ТЕГ-т хүргүүлэх
4. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, тайлан, өөрчлөлт, зардлын 50%-ийг тусгай дансанд төвлөрүүлсэн байдал, түүний зарцуулалт, буцаан төлөлтийн байдлыг компани бүрээр гаргаж, дэд зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх
5. Байгаль орчны нөхөн сэргээлттэй холбоотой мэдээ, тайлан гаргах
6. АМТХуулийн 42 дугаар зүйлийн хэрэгжилтийн мэдээ, тайлан гаргах
7. Уул уурхайн үйлдвэрлэлийн нөлөөллийн бүсэд амьдарч байгаа иргэд, өрхийн мэдээ, судалгаа гаргах гэх мэт

Иргэдэд нээлттэй ил тод мэдээлэх, олон талын оролцоотой хэлэлцүүлэг өрнүүлэх ажлын хүрээнд:


1. Мэдээллийн самбар гаргах, шинэчлэх /байршил оновчтой газар байх, гудамжны том самбар байж болно/
2. Цахим хуудаснаа ил тод байдлын булан гаргаж, сурталчилах
3. Тогтмол уулзалт, зөвлөгөөн зохион байгуулах
4. Нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулах
5. Орон нутгийн телевиз, радио, өдөр тутмын сонингоор нийтлэл, сурвалжлага, мэдээ явуулах
6. Зурагт хуудас, тараах материал бэлдэж, хүргүүлэх
7. Нээлттэй утас ажиллуулах
8. Иргэдийн төлөөлөгчдийн хурал, томоохон арга хэмжээнүүдэд мэдээлэл хийх, илтгэл тавих гэх мэт

Хамтын ажиллагаа, түншлэлийг хөгжүүлэх, сургалт, чадавх бэхжүүлэх үйл ажиллагаа


1. Төрийн байгууллагуудын уялдаа холбоог хангах чиглэлээр албан уулзалт зохион байгуулах, албан бичгийн харилцааг идэвхжүүлэх
2. Төр, компани, иргэний нийгмийн харилцан ойлголцол, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор сургалт зохион байгуулах, харилцан ойлголцолын санамж бичиг байгуулах
3. Иргэд, иргэний нийгмийн байгууллага, сэтгүүлчдэд зориулсан сургалт зохион байгуулах
4. Судалгаа, тайлан, мэдээ гаргаж буй албан хаагч нарт сургалт зохион байгуулах
5. Орон нутагт хэрэгжиж буй ижил төрлийн олон улсын байгууллагын төсөл хөтөлбөрүүдтэй уялдуулах гэх мэт

Дэд зөвлөлийн үйл ажиллагааг хэрхэн үр дүнтэй зохион байгуулж, төлөвлөх вэ?

Аливаа үйл ажиллагааг системтэйгээр сайтар төлөвлөвөл гарах үр дүн илүү байдаг. Тиймээс ОҮИТБС-ын дэд зөвлөлийн үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэх үүднээс дараах үндсэн мөчлөгийг сайтар төлөвлөх хэрэгтэй.



Үр дүнд чиглэсэн оновчтой зорилго, зорилт гэж ямар байх вэ?



Зорилго, зорилтуудаа маш тодорхой тодорхойлсны үндсэн дээр зорилго, зорилт хангагдсан эсэхийг үнэлэх гүйцэтгэлийн үнэлгээний хуудас буюу үзүүлэлттэй байх нь илүү үр дүнтэй. Тухайлбал зарим ажлыг тоон үзүүлэлтээр хувьчилж тодорхой үнэлэх шаардлагатай болдог ч зарим ажлууд урт хугацаанд үр дүнгээ үзүүлэх, үнэлэхэд хүндрэлтэй үйл ажиллагаанууд байдаг.

Тухайлбал, ОУИТБС-ын хүрээнд хийгддэг ил тод байх, иргэдэд нээлттэй мэдээлэх ажлын үр дүнг үнэлэе гэж үзвэл хэдэн хүнд мэдээлэл хүргэсэн, хэдэн хүн оролцсон, хэдэн хүн мэдээлэл авсан, хэдэн самбар, хэвлэмэл бүтээгдэхүүн гаргасан гэх зэрэг мэдээллийн хүртээмжийг үнэлж болох ч тухайн иргэн мэдээллийг хүлээж аваад ямар хариу үйлдэл үзүүлсэн, мэдээллийн мөрөөр ажил хэрэг болгож явсан эсэх, улмаар хариуцлага нэмэгдсэн эсэх гэх зэрэг алсын зорилго, зорилтуудын үр дүнг гаргаж тооцоход нарийн төвөгтэй байдаг. Иймд ямагт судалгаа авах, эргэх холбоотой ажиллах нь үр дүн гарч буй эсэхийг дүгнэхэд дөхөм болдог.

ОҮИТБС-ын тайлангаар ил тод мэдээлэгддэг татвар, төлбөрүүд

- ✓ Татварын ерөнхий хуулийн 5.1 дэх заалтад Монгол Улсын татвар нь татвар, хураамж, төлбөр /цаашид “татвар” гэх /-өөс бүрдэнэ гэсэн байдаг.
- ✓ ОҮИТБС-ын тайлангийн 3-р хэсэгт 47 нэр төрлийн төлбөрийн урсгал тайлагнагддаг ба тэдгээрийг жил бүрийн аудитын нэгтгэлээр тулган баталгаажуулдаг.
- ✓ Татвар, төлбөр, хураамж нь төсөвт төвлөрдөг байдлаараа улсын төсөвт төлсөн, орон нутгийн төсөвт төлсөн гэж ангилагдана. Дараах хүснэгтээс татвар, төлбөрийн урсгалын тайлбарыг харна уу.

№	Төрөл	Тайлбар
А- Үндсэн төрлүүд		
1. Улсын төсөвт төлсөн албан татвар, төлбөр, хураамж, ногдол ашиг		
1.1.1	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар нь Монгол улсын аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу аж ахуйн нэгж байгууллагын нийт ашиг эсвэл орлогоос тооцсон татвар юм. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 10%-25%-иар тооцдог бөгөөд жилийн ашиг нь 3 тэр бум хүртэл 10%-иар, 3 тэр бумаас дээш дүнгээс дээш гарсан дүнгийн 25%-иар тооцдог.
1.1.2	Гаалийн албан татвар	Гаалийн албан татвар нь Монгол улсад импортлосон барааны үнийн 5%-иар тооцдог. Мөн гаалийн албан татварыг эмнэлэгийн тоног төхөөрөмж болон зарим бүтээгдэхүүнүүд 0 хувиар тооцож ногдуулдаг. Зарим төрлийн экспортын бараа бүтээгдэхүүнийг гаалийн албан татвараас чөлөөлсөн байдаг. Тухайлбал ноолуур, зэс, хаягдал төмөр, хөнгөн цагаан, гууль.
1.1.3	Нэмэгдсэн өртгийн албан татвар	НӨАТ-ыг Монгол улсад үзүүлсэн бараа, ажил үйлчилгээ, мөн гаалиар орж ирж байгаа барааны импортод 10%-иар ногдуулдаг.
1.1.4	Автобензин, дизелийн түлшний онцгой албан татвар	Монгол улсад импортлосон болон үйлдвэрлэсэн авто бензин дизелийн түлшинд ногдуулсан онцгой албан татвар.
1.1.5	Автобензин, дизелийн түлшний албан татвар	Монгол улсын нутаг дэвсгэрт авто бензин дизелийн түлш, бүх төрлийн газ боловсруулсан, импортлосон худалдааны байгууллага, гадаадын иргэн, харъяалалгүй иргэнд ногдуулсан албан татвар.
1.2.1	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр болон нэмэлт төлбөр	Ашигт малтмалын лиценз эзэмшигч уул уурхайн үйл ажиллагаанаас бүх төрлийн ашигт малтмал (баялаг) олборлосны төлөө төлж байгаа нэмэлт төлбөр

№	Төрөл	Тайлбар
1.2.2	Ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр	Хайгуулын лицензийн төлбөрийг Монгол улсын ашигт малтмалын хуульд заасны дагуу хайгуулын талбай га бүрт тогтоосон хэмжээгээр лиценз эзэмшигч нь төлнө. Монгол улсын ашигт малтмалын хуульд заасны дагуу олборлолтын нэгж талбай хэмжээгээр ашиглалтын төлбөрийг лиценз эзэмшигч төлнө.
1.2.3	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуулхийс энордын нөхөнтөлбөр	Улсын төсвийн хөрөнгөөр хийсэн хайгуулын ордын нөхөн төлбөрийг засгийн газарт буцаан төлнө.
1.2.4	Гадаадын мэргэжилтэн, ажилчны байрны төлбөр	Монгол улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа хувь хүн болон аж ахуй нэгж гадаад иргэнийг авч ажиллуулсны төлбөрийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төлнө.
1.2.5	Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр тухайн жилд гарын үсэг зурсны урамшуулал	Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу төрийн өмчийн хороонд төлсөн урамшуулал.
1.2.6	Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолт эхэлсний урамшуулал	Монгол улсын засгийн газарт төлсөн үйлдвэрлэл эхлүүлсний шагнал
1.2.7	Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр тухайн жилд төвлөрүүлсэн сургалтын урамшуулал	Монгол улсын засгийн газарт бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу төлсөн гэрээлэгч сургалт явуулсны шагнал
1.2.8	Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан нөхцлийн дагуу төвлөрүүлсэн талбайндэнчин	Олборлолт явуулах газрын нөхцөл байдлаас хамааран Гэрээлэгчийн зүгээс төлж буй барьцаа төлбөр.
1.2.9	Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан нөхцлийн дагуу төвлөрүүлсэн захиргааны үйлчилгээний шимтгэл	Гэрээлэгчийн зүгээс Монгол улсын Засгийн Газарт төлөх захиргаа болон үйлчилгээний төлбөр.
1.2.10	Бүтээгдэхүүн хуваах гэрээнд заасан нөхцлийн дагуу төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг дэмжсэн төлбөр	Гэрээлэгчийн зүгээс санал болгосон, Засгийн Газарт төлөх дэмжлэг үзүүлсний төлбөр.
1.2.11	Агаарын бохирдлын төлбөр /нүүрс/	Олборлож буй нүүрсний килограмм тутамд ноогдуулах 1 төгрөгийн төлбөр.
1.2.12	Аж ахуйн нэгжээс төлсөн ажиллагчдын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл	Гэрээний үндсэн дээр бүх төрлийн аж ахуйн нэгж, байгууллагууд, төрийн байгууллагууд, шашны болон бусад байгууллага, Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй гадаадын аж ахуйн нэгжүүдэд гэрээний үндсэн дээр ажиллаж буй Монгол улсын иргэд, гадаадын иргэд, харьяалалгүй хүмүүс нийгмийн даатгалыг заавал төлөх бөгөөд үүнд тэтгэвэрийн даатгал, эрүүл мэндийн даатгал, үйлдвэрийн ослын даатгал, ажилгүйдлийн болон ажлын байрны өвчлөлийн даатгалд заавал хамрагдсан байна.

№	Төрөл	Тайлбар
1.3.1	Гаалийн үйлчилгээнийхураамж	Гаальд мэдүүлэг гарган өгч буй этгээдийн төлөх гаалийн асуудал эрхэлсэн төв байгууллагын баталсан хэмжээний төлбөр. Гаалийн бүрдүүлэлтийн үйлчилгээний төлбөрийн хэмжээ нь үйлчилгээг хүргэхэд гарсан зардалтай уялдаатай байж, улсын орлогод орно.
1.4.1	Төрийн өмчийн ногдол ашиг	Төрийн өмчит компаниудаас Төрийн өмчийн хороонд төлсөн ногдол ашиг.
1.5.1	Засгийн газрын хүлээн авсан урьдчилгаатөлбөрүүд	Монгол улсын Засгийн Газарт төлсөн урьдчилгаа төлбөр.
1.5.2	Цөмийн энергийн тухай хуулийн дагуу Засгийн газарт ногдох орлого	Улсын төсвийн нөөцийг нь тогтоосон цацраг идэвхи бүхий ашигт малтмалын ордыг хуулийн этгээдтэй хамтран ашиглаж буй бол тухайн аж ахуйн нэгжийн 51-ээс доошгүй хувийг үнэ төлбөргүйгээр төрийн өмчид авна. Цацраг идэвхи бүхий ашигт малтмалын нөөцийг улсын төсвийн бус санхүүжилттэйгээр тогтоож, улсын нөөцийн бүртгэлд бүртгүүлсэн бол тухайн тусгай зөвшөөрлийг эзэмшиж буй бол аж ахуйн нэгжийн 34-өөс доошгүй хувийг үнэ төлбөргүйгээр төрийн өмчид авна.
1.5.3	Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу Засгийн газарт ногдох газрын тосны орлого	Газрын тосны бүтээгдэхүүн борлуулсанаас Засгийн Газарт ноогдох хувь хэмжээ.
1.5.4	Үүнээс: байгалийн нөөцашигласны төлбөр	Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь төв болон орон нутгийн захиргаанд олборлосон, тээвэрлэсэн, ашигласан нийт ашигт малтмалын үнийн дүнгээс төлдөг нөөцийн төлбөр.
1.6.1	Торгууль (Улсын төсөв)	ҮТЕГ, МХЕГ, НДЕГ зэрэг төрийн байгууллагуудаас хийсэн шалгалтаар илэрсэн зөрчилд ноогдуулсан торгууль.
1.6.2	Нөхөн төлбөр (Улсын төсөв)	ҮТЕГ, МХЕГ, НДЕГ зэрэг төрийн байгууллагуудаас хийсэн шалгалтаар илэрсэн зөрчилд хамаарах нөхөн төлбөр.
1.6.3	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар	Зарим бүтээгдэхүүний үнийн гэнэтийн өсөлтөөс үүдсэн нэмэлт орлогод ноогдуулан, тусгай санд төвлөрүүлэх татвар.
1.6.4	Бусад (Улсын төсөв)	Дээр дурсан татвар, төлбөр хураамжаас бусад, Монгол улсын Төсвийн тухай хуулийн дагуу нэгдсэн төсөвт төлөгдөх ёстой төлбөр.

№	Төрөл	Тайлбар
2. Орон нутгийн төсөвт төлсөн татвар, хураамж, төлбөр, ноогдол ашиг		
2.1.1	Үл хөдлөх хөрөнгийн татвар	0.6% - 1%-иар ноогдуулсан үл хөдлөх хөрөнгийн татвар бөгөөд тухайн хөрөнгийн хэмжээ, байршил болон зах зээлийн эрэлт зэргээс хамаарна.
2.1.2	Авто машин өөрөө явагч хэрэгслийн татвар	Иргэд, аж ахуйн нэгж байгуулагуудын эзэмшилд буй, Монгол улсын нутаг дэвсгэр дээр ашиглаж буй автомашинд ноогдуулах татвар.
2.2.1	Газрын төлбөр	Төрийн өмчийн газрыг эзэмшиж, ашигласны төлөө иргэд, аж ахуйн нэгжүүдийн төлөх төлбөр.
2.2.2	Ус ашигласны төлбөр	i)хүн амын унд, ахуйн болон үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан ус; (i)уул уурхайн үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан ус; (iii)эмчилгээ, сувилгаа, халаалт болон үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан рашаан; (iv)эрчим хүч үйлдвэрлэх, тээвэр хийх болон усны амьтан, ургамал өсгөн үржүүлэх зэрэг үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан ус, рашааны орчинд төлөх төлбөр.
2.2.3	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зүгээс борлуулсан, ашигласан,тээвэрлэсэн түгээмэл тархацтай ашигт малтмалын хэмжээнд ноогдох төлбөр.
2.2.4	Гадаадын мэргэжилтэй ажилтны ажлын байрны төлбөр (Орон нутгийн төсөв)	Монгол улсын нутаг дэвсгэр дээр ажиллаж буй хуулийн этгээд болон хувь хүмүүс нь гадаадын иргэдэд ажлын байр гарган ажиллуулж орлого олох боломжийг хангаж буй тохиолдолд төлөх төлбөр.
2.2.5	Бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу хүлээн авсан тусламж дэмжлэг	Газрын тосны компаниудын зүгээс БХГ-ний дагуу Монгол улсын ҮГ-т үзүүлсэн тусламж дэмжлэг.
2.4.1	Төрийн өмчийн ноогдол ашиг	Орон нутгийн өмчид аж ахуйн нэгжээс төрийн өмчийн хвь хэмжээнд хамаарах хувьцааны ноогдол ашиг.
2.5.1	Торгууль (Орон нутгийн төсөв)	Орон нутгийн татварын алба, мэргэжлийн хяналт, нийгмийн даатгалын зэрэг төрийн байгууллагуудаас хийсэн шалгалтаар илэрсэн зөрчилд ноогдуулсан торгууль болон алданги.
2.5.2	Нөхөн төлбөр (Орон нутгийн төсөв)	Орон нутгийн татварын алба, мэргэжлийн хяналт, нийгмийн даатгалын зэрэг төрийн байгууллагуудаас хийсэн шалгалтаар илэрсэн зөрчилд хамаарах нөхөн төлбөр.
2.5.3	Байгаль хамгаалах зардлын 50 хувийг тусгай дансанд шилжүүлсэн дүн	Байгаль хамгаалах зардлын 50%-тэй тэнцэх хэмжээний мөнгөн дүнг хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн жилдээ тухайн сумын захиргааны нээсэн тусгай дансанд байршуулна.
2.5.4	Бусад (Орон нутгийн төсөв)	2.1.1-2.5.3 дээр дурдсан татвар, төлбөр, хураамж зэргээс бусад төлбөр- Төсвийн тухай хуулийн дагуу аймгийн төсөвт төлөх.

Татвар, төлбөр, хураамжийг мэдүүлэхэд анхаарах асуудлууд:

- ✓ Тайлан гаргасан мэргэжилтэн нь тайланг гаргах явцдаа тайланд тусгасан орлогын дэлгэрэнгүй бүртгэл, жагсаалтыг бэлтгэх (Ямар аймаг сумын, ямар дансанд , хэзээ тушаасан болох тухай). Энэ жагсаалт гаргасан тохиолдолд аудитын нэгтгэлээр зөрүү үүссэн үед тодруулгыг хийхэд хялбар байх болно.
- ✓ Харилцан хамааралтай бусад компанийн орлоготой холин тайлагнахгүй байх. Төлбөрийн баримт дээр төлбөр хамаарах ААН-ийн нэр, регистрийг тодорхой бичих. Гаргацгүй, ойлгомжгүй бол тодорхойгүй орлогод бүртгэгддэг

- ✓ АТБӨЯХ-ийн албан татвар дээр зөрүү их үүсдэг. Шалтгаан нь ихэвчлэн тээврийн хэрэгслийнхээ шилжилт хөдөлгөөнийг ТА-нд бүртгүүлээгүйгээс болдог. Иймд жилийн эцэст татварын албаны мэдээллийн санд бүртгэлтэй байгаа АТБӨЯХ-ийн бүртгэл болон төлөлттэй тулган нягтлах шаардлагатай.
- ✓ Татварын орлогыг зөвхөн тухайн төрлийн татварын дансанд тушаах (Ямар нэгэн сангийн дансанд тушаахгүй байхад анхаарах. Газар болон усны төлбөрийг байгаль хамгаалах санд тушаасан тохиолдлууд давтагдсан.)
- ✓ Татварын алба татварын хяналт шалгалтын актаар ногдуулж төлүүлсэн татвар, төлбөрийг тухайн холбогдох нэр төрлийн татварын орлогод тооцон ОУИТБСТ тайлагнадаг. Үүнийг татвар төлөгч хүү торгуулийн орлого дээр тайлагнан зөрүү үүсгэдэг тул анхаарна уу.
- ✓ Нэмэгдсэн өртгийн албан татвар нь Гаалийн ерөнхий газарт болон Татварын ерөнхий газарт төлөгддөг тул ангилан салгаж бүртгэл хийх.

Хандив, дэмжлэг тайлагнахад анхаарах асуудлууд.

ОУИТБС-ын тайлангаар олборлох үйлдвэрлэлийн компаниас төр, засгийн байгууллага болон төрийн бус байгууллага, иргэдэд үзүүлсэн мөнгөн болон мөнгөн бус хандив, дэмжлэгийг ил тод болгодог. Үүнээс төр засгийн байгууллагад үзүүлсэн хандив, дэмжлэгийг аудитаар тулган баталгаажуулдаг.

3. Төрийн байгууллагуудад өгсөн хандив, тусламж		
3.1	Яам агентлагуудын хүлээн авсан мөнгөн хандив, тусламж	Олборлох үйлдвэрлэлийн компаниудын зүгээс яам, агентлагуудад өгсөн мөнгөн хандив, тусламж.
3.2	Яам агентлагуудын хүлээн авсан мөнгөн бус хандив, тусламж	Олборлох үйлдвэрлэлийн компаниудын зүгээс яам, агентлагуудад өгсөн мөнгөн бус хэлбэрийн хандив, тусламж.
3.3	Аймаг, нийслэлд өгсөн мөнгөн хандив, тусламж	Олборлох үйлдвэрлэлийн компаниудын зүгээс аймаг, нийслэлд өгсөн мөнгөн хандив, тусламж.
3.4	Аймаг, нийслэлд өгсөн өгсөн мөнгөн бус хандив, тусламж	Олборлох үйлдвэрлэлийн компаниудын зүгээс аймаг, нийслэлд өгсөн мөнгөн бус хэлбэрийн хандив, тусламж.
3.5	Сум, дүүрэгт өгсөн мөнгөн хандив, тусламж	Олборлох үйлдвэрлэлийн компаниудын зүгээс сум, дүүрэгт өгсөн мөнгөн хандив, тусламж.
3.6	Сум, дүүрэгт өгсөн мөнгөн бус хандив, тусламж	Олборлох үйлдвэрлэлийн компаниудын зүгээс сум, дүүрэгт өгсөн мөнгөн бус хэлбэрийн хандив, тусламж.
3.7	Бусад байгууллагуудад өгсөн мөнгөн хандив	Олборлох үйлдвэрлэлийн компаниудын нийслэл, дүүргийн нийгмийн даатгалн хэлтэс, татварын албад, Монгол улсын Хил хамгаалах байгууллага зэрэг байгууллагуудад өгсөн мөнгөн хандив, тусламж.
3.8	Бусад байгууллагуудад өгсөн мөнгөн бус хандив	Олборлох үйлдвэрлэлийн компаниудын нийслэл, дүүргийн нийгмийн даатгалн хэлтэс, татварын албад, Монгол улсын Хил хамгаалах байгууллага зэрэг байгууллагуудад өгсөн мөнгөн бус хэлбэрийн хандив, тусламж.

Жил бүрийн аудитын нэгтгэлээр хандив, дэмжлэгт их зөрүү үүсдэг. Ихэнх тайлбар нь компани талаас төлсөн гэж мэдүүлэхэд төрийн байгууллага талаас хүлээн аваагүй гэсэн

тайлбар олон гардаг. Учир шалтгааныг тодруулан үзэхэд компани тухайн аймаг, орон нутагт үзүүлсэн хандив, дэмжлэг нь ЗДТГ-ын шууд орлого болоогүй, хүлээн авагч нь өөр этгээд байх зэрэг шалтгаануудаас гол төлөв зөрүү үүсдэг. Иймд мөнгөн болон мөнгөн бус хандив, дэмжлэгийг хэрхэн бүртгэх талаар Сангийн яамны Нягтлан бодох бүртгэлийн газрын албан тайлбарыг хавсаргав.

Мөнгөн болон мөнгөн бус хандив, дэмжлэгтэй холбоотой асуудлууд?

Монгол улсын “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 10.1 дүгээр зүйлд Аж ахуйн нэгж байгууллага нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад, төсөвт байгууллага нь Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн санхүүгийн тайлангаа гаргана.

Төсвийн тухай хуулийн 25.1-д Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу бүрэн аккрузаль суурьтай нягтлан бодох бүртгэл хөтөлнө.

УСНББОУС-ыг дараах байгууллагууд мөрдөнө. Үүнд:

- Төсөвт байгууллага
- Засгийн газар ба орон нутгийн засаг захиргаа
- Засгийн газрын холбогдох байгууллага, харъяа байгууллага
- Харин төрийн өмчийн бизнесийн байгууллага мөрдөхгүй.

Аливаа хандив, дэмжлэгийг УСНББОУС 23 дугаар буюу Арилжааны бус ажил гүйлгээний орлого гэсэн стандартаар бүртгэнэ. Уг стандартаар хандив, дэмжлэгийг “бэлэг ба хандив” болон “хариу төлбөргүй үйлчилгээ” гэж хоёр өөрөөр ангилан авч үзсэн байна.

Бэлэг ба хандив гэдэг нь:

- Ирээдүйн эдийн засгийн өгөөж буюу үйлчилгээний боломж уг байгууллагад орох магадлалтай бөгөөд тухай хөрөнгийн бодит үнэ цэнийг найдвартай хэмжиж чадах тохиолдолд бэлэг ба хандивыг хөрөнгө ба орлого гэж хүлээн зөвшөөрнө.
- Барааг хүлээн авах буюу барааг хүлээн авах тохиролцсон хэлцэлтэй тохиолдолд хариу төлбөргүй барааг хөрөнгө гэж хүлээн зөвшөөрдөг
 - Нөхцөлгүй хүлээн авсан бол орлого
 - Нөхцөлтэй бол өр төлбөр хүлээн зөвшөөрөх ба нөхцөл биелэгдсэнээр өр төлбөрийг бууруулж, орлогыг хүлээн зөвшөөрнө.

Хариу төлбөргүй үйлчилгээ гэдэг нь:

- Хариу төлбөргүй үйлчилгээг орлого ба хөрөнгө гэж хүлээн зөвшөөрч болох боловч заавал хүлээн зөвшөөрөхийг шаардахгүй.
- Амлалт
 - Байгууллага нь амласан зүйлсийг хөрөнгө буюу орлого гэж хүлээн зөвшөөрөхгүй
 - Хэрэв амласан зүйл нь хүлээн авагч байгууллагад дараа шилжин ирвэл түүнийг бэлэг хандивтай адилаар хүлээн зөвшөөрнө.

Хөрөнгийн хүлээн зөвшөөрөлт

- Хариу төлбөргүй үйлчилгээнээс бусад арилжааны бус арилжааны ажил гүйлгээнээс бий болсон, хөрөнгийн тодорхойлолтыг хангах нөөцийн орох урсгалыг дараах тохиолдолд, зөвхөн хөрөнгө гэж хүлээн зөвшөөрнө.
 - Хөрөнгөтэй холбоотой ирээдүйн эдийн засгийн өгөөж буюу үйлчилгээний боломж нь тухайн байгууллагад орох магадлалтай байх

- Хөрөнгийн бодит үнэ цэнийг найдвартай хэмжиж болохоор байх

Анхны хүлээн зөвшөөрөлтөөр хөрөнгийг хэмжих

- 42. Арилжааны бус ажил гүйлгээгээр олж авсан хөрөнгийг тухайн олж бэлтгэсэн өдрийн бодит үнэ цэнээр анх хэмжих ёстой.
- УСНББОУС 12, бараа материал, УСНББОУС 16, Ашиг олох зорилготой үл хөдлөх хөрөнгө, УСНББОУС 17, Үндсэн хөрөнгө-ийн дагуу арилжааны бус ажил гүйлгээгээр олж авсан хөрөнгийг түүнийг олж бэлтгэсэн өдрийн бодит үнэ цэнээр хэмждэг.

Тэгэхээр аливаа хандив, дэмжлэгийг бүртгэхдээ дараах зүйлсийг анхаарах хэрэгтэй.

- ✓ Таны үзүүлж буй бэлэг, хандив нь хүлээн авч буй байгууллагын хэрэгцээг хангахуйц, эдийн засгийн өгөөжийг хангаж байна уу?
- ✓ Таны үзүүлж буй хандив, дэмжлэг нь хүлээн авагчдаа эдийн засгийн үр өгөөжийг үзүүлэхүйц хандив уу? эсвэл нийгмийн сайн сайхны төлөө нэг удаа үзүүлж буй хариу төлбөргүй үйлчилгээ юу? гэдгээ сайтар ялгах хэрэгтэй.
- ✓ Хариу төлбөргүй үйлчилгээ буюу тухайн аймаг, орон нутагт үр өгөөжийг нь нийт оршин суугчид хүртэхээр замын цас цэвэрлэх, бохирдсон газрын хөрсийг цэвэрлэх, гал унтраах зэрэг шинжтэй үйлчилгээ үзүүлсэн бол түүний хүлээн авагч нь тухайн аймаг, орон нутгийн ЗДТГ буюу төрийн байгууллага биш тул хүлээн авагчийг иргэдэд гэж зөв бүртгэх
- ✓ Хандиваар үзүүлж буй хөрөнгийг үнэлсэн үнэлгээ нь тухайн хүлээн авагчийн үнэлгээтэй заавал таарах албагүй. Тухайн хүлээн авагч нь зах зээлийн бодит, үнэ цэнээр бүртгэх тул үнэ, өртгийн зөрүү үүсч болзошгүй.
- ✓ Та ямар нэгэн барилга барьж өгч байгаа бол нэг талаас та шууд зардалд бүртгэх боловч тухайн хүлээн авагч нь барилгаа хүлээн аваагүй байгаа тул орлогоор бүртгээгүй байж болно. Энэ нь цаг хугацааны хувьд зөрүү үүсч байгаа тул зөрүү гарах магадлалтай.
- ✓ Аймаг, суманд үзүүлсэн хандив гэдэгт тухайн төрийн байгууллагын бодитоор хүлээн авсан, эдийн засгийн үр өгөөжийг нь хүртэж буй хандив, дэмжлэгийг бүртгэх хэрэгтэй. Хэрэв сургууль, эмнэлэгт үзүүлж буй дэмжлэг бол бусад гэдэг ангилалд тайлагнаж, тайлбарыг дэлгэрэнгүй хийх шаардлагатай.
- ✓ Сум хөгжлийн санд дэмжлэг үзүүлсэн бол хүлээн авагч нь орон нутгийн өмчийн газар байдаг. Тиймээс Сумын ЗДТГ гэж тайлагнахгүй бодит өгөөжийг хүртэж буй хүлээн авагчийг тодорхой бүртгэх шаардлагатай.

Жил бүрийн аудитын нэгтгэлээр тулгардаг асуудлууд, анхаарах зүйлс:

- Компаниудын хаяг байршил, холбогдох утас нь тодорхойгүй, буруу хаяг өгснөөс аудиторуд 200 компанийн холбоо барих тодорхой хаягийг олоход маш их цаг алддаг.
- Зарим компаниуд ОУИТБС-ын ач холбогдол, аудитын нэгтгэлийн ажлын талаар ойлголт бага байгаагаас шаардлагатай мэдээг гаргаж өгөхгүй, хойш тавих, хүнд суртал гаргадаг.
- Аливаа төлбөрийг төлөхдөө бусдын өмнөөс төлбөр төлж, аль компанийн нэр дээр төлж буйгаа тодорхой мэдүүлээгүй нөхцөлд аудитын явцыг их төөрөгдүүлдэг. Иймд бусдын өмчнөөс төлбөр төлөхдөө компанийн нэр, лицензийн дугаарыг нарийн тавьж өгнө үү.
- Маягт бөглөхдөө зарим төлбөрүүдийн ангиллыг андуурдаг тул маягт бөглөх заавартай сайтар танилцана уу.
- Зарим тохиолдолд НББ-ийн аккурэл сууриар бүртгэсэн төлбөрөө ОУИТБС-ын тайланд мэдүүлдэг. ОУИТБС-ын тайлан нь мөнгөн сууриар тайлагнагддаг тул анхаарна уу.
- Дэлгэрэнгүй мэдээлэл өгөхдөө бөөн дүнгээр гаргаж өгдөг. Энэ нь аудитын явцад нэмэлт ажил болдог тул аль болох задаргаа, нарийвчлалтай гаргаж өгнө үү.
- Зөвхөн татварын албанд төлсөн НӨАТ-г тайлагнасан байдаг, иймд гаалийн байгууллага болон татварын албанд төлсөн НӨАТ-г салгаж, тайлагнах ёстой.
- Бусдын өмнөөс гаалийн бүрдүүлэлт хийсэн эсвэл бусдаар гаалийн бүрдүүлэлт хийлгэсэн явдал нь гаалийн үйлчилгээний хураамж ангилалд их хэмжээний зөрүү үүсгэдэг. Иймд гаалийн бүрдүүлэлтийг хувь хүний өмнөөс хийхгүй байх, гаалийн үйлчилгээний хураамжийг дэлгэрэнгүй бүртгэнэ үү.
- Агаарын бохирдлын төлбөрт авто машиныг оруулан тайлагнасан байдаг. ОУИТБС-ын тайланд агаарын бохирдлын төлбөр нь зөвхөн нүүрс олборлосон үйл ажиллагаатай холбоотой төлсөн төлбөр байдаг.
- Татварын нөхөн төлбөр, алданги торгуулийг бүгдийг нь торгуулиар тайлагнасан байдаг. Үүнийг салгаж тайлагнах ёстой.
- Тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн гэрчилгээний эзэмшигчийн өөрчлөлтийг хийгээгүйгээс зөрүү их гардаг. Тээврийн хэрэгслийн гэрчилгээг эзэмшигчийн нэр дээр шилжүүлэх талаар арга хэмжээ авах хэрэгтэй байна.
- Зарим тохиолдолд төрийн байгууллагууд төлсөн бүхий л төлбөрийг тайлагнах сонирхолтой байдгийг анхаарна уу.
- Гаалийн байгууллагад урьдчилж төлсөн төлбөрүүдийг тайлагнасан байх ёстой.

Монголын ОУИТБС-ын ажлын алба